



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/645

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 зүйлийн 29.1.6-ийн "Л" заалт, Монгол улсын төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт, Засгийн газрын 2018 оны 388 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны эрх шилжүүлэх тухай 502 тоот албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хүнс, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж буй ажлын гүйцэтгэлийг хянах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:	Г.Гончигсүрэн	- Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Гишүүд:	Б.Түмэндэмбэрэл	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Н.Тогтохбаяр	-Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн
	Р.Тогтохбаяр	-Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн


Нарийн бичгийн

Дарга:	Ц.Пүрэвсүрэн	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого Төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
--------	--------------	--

2. Сумдад баригдаж байгаа услалтын системүүд, худаг ус, мал угаалгын ванн, агропарк жимс, жимсгэний төсөл арга хэмжээ, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийн ажлын гүйцэтгэл, үр дүнг удирдамжийн дагуу хянан үзэж дүгнэлт гаргаж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3. Энэхүү ажлын хэсгийн ажиллах томилолт, шатахууны зардлыг хавсралтаар баталж дээрх ажлуудын хяналтын зардлаас гаргаж Хүнс, хөдөө аж ахуйн газарт шилжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ




Т.ЖАРГАЛСАЙХАН

02 03181

Zax A/645 Ch

Аймгийн Засаг даргын 2019 оны
10 дугаар сарын 09-ний өдрийн А/645
дугаар захирамжийн хавсралт



ХЯНАЛТ ХИЙХ АЖИЛД ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ

№	Арга хэмжээ	Нэр төрөл	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Зэрэг, Үенч, Булган, Чандмань, Дарви	2000 км	2090 төгрөг	360л бензин	752.400
2	Томилолт	Нийт 6 хүн	5 өдөр	19,500	585.000
3	нийт				1.337.400

-оОо-